



Баталсан хууль нь хүн  
бүрт тэгш үйлчилдэг  
төр л халгийн  
тогтвортой оршдог.

Аристотель

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2024.01.31

## “ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ: МОНГОЛ БА ЯПОН УЛС” СЭДЭВТ ХАМТАРСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР БОЛЛОО

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Япон Улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтарсан 4 дэх удаагийн эрдэм шинжилгээний семинарыг “Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг: Монгол ба Япон улс” сэдвийн хүрээнд өнөөдөр /2024.01.17/ Хуульчдын танхимд амжилттай зохион байгууллаа.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор

(Dr.Jur) Х.Эрдэм-Ундрах хамтарсан семинарыг нээж хэлсэн үгэндээ: Хууль тогтоомж болон эрх зүйн салбарын туршлагаараа Япон улс азид тэргүүлдэг гэж үзэн судалдаг тул хоёр улсын хамтарсан семинарууд манай улсын эрдэмтэн, судлаачдад өгөөж ихтэй байдгийг онцолсон болно.

Харин Япон улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны нэгдсэн хүрээлэнгийн Олон улсын хамтын

ажиллагааны газрын захирал, профессор Шинтаро Найто сүүлийн жилүүдэд хоёр улсад хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгт холбогдох эрх зүйн шинэчлэлүүд хийгдэж байгаа тул цаг үеэ олсон сэдвээр семинар зохион байгуулж байгаад талархаж буйгаа илэрхийлэв.

үргэлжлэл 4-р нүүрт



## Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЧ ШАГНАЛАА ГАРДАН АВЛАА

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, нэрэмжит шүүх эрх мэдлийн болон байгууллагын багш, судлаач, оюутны ардын багш, гавьяат хуульч, доктор, хууль сахиулах байгууллагын ажилтан, эрдэм шинжилгээний илтгэлийн профессор Б.Чимид багшийн сургалт, эрдэм шинжилгээний уралдааны шилдгүүд тодорч, шагналаа



### Судлаачийн ангилалд:

Б.Буянхишиг “Үндсэн хууль ба Үндсэн хуульчилсан хуулийн онолын хөгжил Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог бүрдүүлснээр төгөлдөржих нь” сэдвээр тэргүүн байрт;

З.Янжиндулам “2023 оны Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт ба органик хуулийг батлахтай холбогдсон асуудал” сэдвээр дэд байрт;

Р.Ануурад, Н.Хулан нар “Эрх зүйн хэм хэмжээний шатлал: Үндсэн хуульчилсан хууль” сэдвээр гутгаар байрт;



Б.Ариунзаяа, Р.Оюундэлгэр нар Б.Мөнх-Эрдэнэ “Үндсэн хуулийн “Монгол Улсын Үндсэн хуульд хэрэгжилт ба органик хуулиудын органик хуулийн хүрээ, батлах босго, үүрэг, хэрэгцээ шаардлага” сэдвээр хяналтыг тодорхойлж, зохицуулах тусгай байрт тус тус шалгарлаа. асуудал” сэдвээр тусгай байрт;



#### Оюутны ангилалд:

Э.Хишигсүрэн “Үндсэн хуульчилсан хууль ба хэм хэмжээний негатив хяналт” сэдвээр дэд байрт;

Анхбат “Сонгуулийн холимог тогтолцооны суудал хуваарилалтыг Үндсэн хуульд тусгахтай холбоотой эрх зүйн асуудал” сэдвээр гутгаар байрт;

Б.Сарантуяа “Үндсэн хуульчилсан хууль боловсруулалт түүний практик хэрэглээнд тулгамдаж буй асуудал ба боломж” сэдвээр тусгай байрт;



Х.Мичидмаа “Үндсэн хуульчилсан хуулийн мөн чанар ба түүнийг батлах тусгайлсан шалгуур тогтоох нь” сэдвээр тусгай байрт;

А.Бямбадалай “Үндсэн хуулийн Улсын Их Хурлын тарахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилсан хуулиар тодруулах хэрэгцээ, шаардлага” сэдвээр тусгай байрт тус тус шалгарлаа.



...үргэлжлэл

### Тус семинарт


Япон улсын Сургалт, судалгааны нэгдсэн хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Кэйсүкэ Гото “Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг-Япон улс” ;

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur) Х.Эрдэм-Ундрах “Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өөрчлөлт, шинэчлэл: Монгол улс” ;


Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат (LL.M), О.Энххүслэн (LL.M) нар “Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдал, тус гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал” ;

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтсийн Ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Н.Амарзаяа “Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны онцлог” сэдэвт илтгэлийг тус тус хэлэлцүүлэв.

Хамтарсан семинарт Япон Улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны нэгдсэн хүрээлэнгийн (RTI) Олон улсын хамтын ажиллагааны газар (ICD), Монгол Улсаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газар, Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, ГХУСАЗЗАА, Шихихутуг Их сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид оролцож хэлэлцүүлэг өрнүүлэв.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur) Х.Эрдэм-Ундрах



Япон улсын Хууль зүйн яамны Сургалт, судалгааны нэгдсэн хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын захирал, профессор Шинтаро Найто



Япон улсын Сургалт, судалгааны нэгдсэн хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Кэйсүкэ Гото



Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтсийн Ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Н.Амарзаяа




Хэлэлцүүлгийн үеэр



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат




## ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ХҮЧИНДЭХ, ХҮН  
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОРИХ ЯЛЫН  
ДЭЭД ХЭМЖЭЭ 20 ЖИЛ БАЙСНЫГ 25 ЖИЛ  
БОЛГОН НЭМЭГДҮҮЛСЭН.

...



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ХҮЧИНДЭХ, ХҮН  
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ  
ХУГАЦААГ ЗОГСООЖ, ХОХИРОГЧИЙГ 18 НАСАНД  
ХҮРСНИЙ ДАРАА ТООЛЖ ЭХЭЛНЭ.

...

## ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨӨС



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ  
ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДҮҮДИЙГ ХУГАЦААНААС НЬ  
ӨМНӨ СУЛЛАХГҮЙ, ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХГҮЙ.

...




ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭД ЭРХ МЭДЭЛ,  
АЛБАН ТУШААЛЫН БАЙДЛАА УРВУУЛАН  
АШИГЛАХ, ХАХУУЛЬ АВАХ, ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР  
ХӨРӨНГӨЖИХ ЗЭРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БОЛ  
ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС НЬ  
ӨМНӨ СУЛЛАХГҮЙ.

...

# “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА



## Бүтээл хүлээн авах хугацаа:

I улирлын дугаарт нийтлэх  
бүтээл- I сарын 31 хүртэл  
Англи хэл дээрх тусгай дугаарт  
нийтлэх бүтээл- X сарын 31  
хүртэл

## Хянан магадлалын хураамж:

100,000 төгрөг

## Цахим шуудан:

lawjournal@legalinstitute.mn

## Холбоо барих утас:

99247620



1800-1202



ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН  
ЛАВЛАХ ДУГААРТ **08:30-17:30** ЦАГИЙН  
ХОРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР  
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ



## ХУУЛЬЧ ШАТАРЧДЫН УЛАМЖЛАЛТ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Ардчилсан Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан 2009 оноос эхлэн хуульч шатарчдын дунд жил бүр зохион байгуулагддаг Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Бяраагийн Чимидийн нэрэмжит 15 дахь удаагийн уламжлалт шатрын тэмцээнийг 2024 оны 2 дугаар сарын 3-ны өдөр зохион явуулна.

**Тэмцээний зорилго:** Хуулийн байгууллагуудын хуульч шатарчдын дунд шатрын спортыг хөгжүүлэх, оюун ухааны хүч чадал, авьяасыг сорих, оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох.

**Зохион байгуулагч:** "Чимид сан", Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхим, "Цогц-Эрх партнерс" ХХН, Монголын шатрын холбоо

**Тэмцээнд оролцох байгууллагууд:** ҮХЦ, УДШ, УЕПГ, ШЕЗ, ХЭҮК, ХЗДХЯ, УИХТГ, ЦЕГ, ТЕГ, АТГ, ШШГЕГ, ХЗҮХ, ШШЕГ, МУИС-ХЗС, МОУА, МХХ, МӨХ, МНТ

**Хаана:** СБД, 1-р хороо, Төв шуудангийн чанх урд, Эко Интернэйшнл Трэйд Тауэр барилгын 9 давхарт, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуульчдын танхимд

**Тэмцээний нээлт:** 2024 оны 2 дугаар сарын 3, Бямба гараг, 09:00 цаг

**Тэмцээн явуулах журам:** Рапид хэлбэрээр, Швейцарь системээр 9 тавил  
Цагийн хяналт нэг талдаа 15 минут.

**Бүртгэл:** 2024 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 15:00 цаг хүртэл [enkhjin@legalinstitute.mn](mailto:enkhjin@legalinstitute.mn) и-мэйл хаягаар мэдээллээ илгээнэ үү.

Утас: 88040838

### Байр, шагнал:

|                 |                                    |
|-----------------|------------------------------------|
| I байр - 1      | Цом, өргөмжлөл 400'000 төгрөг, ном |
| II байр - 1     | Өргөмжлөл, 300'000 төгрөг, ном     |
| III байр - 1    | Өргөмжлөл, 200'000 төгрөг, ном     |
| Тусгай байр - 3 | Өргөмжлөл, 100'000 төгрөг, ном     |

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС